

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН
/АХЛАХ/ БАЙЦААГЧИЙН ЗӨВЛӨМЖ**

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар 15170,
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, барилгачдын
талбай 13, Засгийн Газрын XII байр E-mai: info@
[inspection.gov.mn](mailto:info@inspection.gov.mn), <http://www.inspection.gov.mn>

2016.04.21 № 08/027/01

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний
тээвэрлэлтийн аюулгүй байдлыг
хангах тухай

АСЕМ-ийн орнуудын дээд хэмжээний 11 дэх удаагийн чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулан явуулах ажлын бэлэн байдлыг хангуулах үүднээс Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Дэд бүтцийн хяналтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн хяналтын газраас чуулга уулзалтанд оролцогчдын хүнсний аюулгүй байдал болон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааг хангуулах зорилгоор энэхүү зөвлөмжийг хүргүүлж байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2015 онд хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлтийн байдалд хийсэн тандалт судалгаагаар төв, орон нутгийн хэмжээнд хүнсний үйлдвэрийн 210 буюу 54.7%, худалдааны 629 буюу 57.4% нь хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын бус тээврийн хэрэгслээр болон өөр бүтээгдэхүүнтэй хамт тээвэрлэж байгаа, зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээс 3600 дээжийг итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулахад 7.9%-д гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян илэрч бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлсэн нь тогтоогдсон юм.

Иймд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч та бүхэнд дараахь зүйлүүдийг анхааралдаа авч, хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

Нэг.Тээвэрлэгч /тээврийн хэрэгсэл бүхий үйлдвэрлэгч, худалдаа эрхлэгч/-дэд тавих нийтлэг шаардлага:

1.1 Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүнийг техникийн хувьд бүрэн, иж бүрдэлтэй, техникийн хяналтын үзлэг тооллогод хамрагдсан, хөдөлгөөний болон экологийн аюулгүйн шаардлагуудыг бүрэн хангасан, тусгай зориулалтын битүү тэвш бүхээг бүхий зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх;

1.2 Тээвэрлэгч, тээвэрлүүлэгч, үйлдэрлэгчид хоорондоо тээвэрлэлтийн гэрээ байгуулах;

1.3 Үйлдвэрлэгч, худалдаа эрхлэгч бараа, бүтээгдэхүүнийг өөрийн өмчлөлийн тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг тохиолдолд тээврийн хэрэгслийг хадгалах, түүнд засвар үйлчилгээ хийх байр талбайтай, автотээврийн мэргэжлийн инженер техникийн ажилтан, мэргэшсэн жолоочтой байхын зэрэгцээ тээврийн хэрэгсэл нь эдэлгээний баталгаат гүйлтийн нөөц ихтэй байх;

1.4 Өөрийн өмчлөлийн тээврийн хэрэгслээр бараа, бүтээгдэхүүнийг тээвэрлэдэг үйлдвэрлэгч, худалдаа эрхлэгчид тээврийн хэрэгслийг ажилд гарахад нь техникийн бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн нөхцлийг хэрхэн хангасныг шалгаж, шалгасан бүртгэлийг жолоочийн замын хуудаст гарын үсгээр баталгаажуулан тэмдэглэх, мөн жолоочийг жолоодох чадварын үзлэгт тогтмол оруулж ажилд гаргаж байх;

1.5 Тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн нэмэгдэл төхөөрөмж, хэрэгслийн аюулгүй ажиллагааг хангах мэргэжлийн, мэргэшсэн ажилтантай байх;

1.6 Автотээврийн хэрэгсэл бүрт техник ашиглалтын хувийн хэргийг нээж, түүнийг хөтлөх албан тушаалтныг томилж ажиллуулах;

1.7 Тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн битүү тэвш, бүхээгт түргэн гэмтэх, эмзэг хүнсний бүтээгдэхүүнийг бохирдуулах, эвгүй үнэр оруулах, тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодис зэрэг ачаатай хольж тээвэрлэхийг хориглох;

1.8. Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэх тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, түүний битүү тэвш, бүхээгт тусгайлан гаргасан гарфикийн дагуу ариутгал тогтмол хийх;

1.9 Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл бүрийг угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэх бодис, материалаар хангасан байх;

1.10 Тээвэрлэлт, ачиж буулгах явцад ачааны бүрэн бүтэн байдал, чанарыг алдагдуулахгүйн тулд стандартын баглаа боодол, сав хайрцаг, шошго, хаяг битүүмжлэл зэргийг урьдчилан хангуулж тээвэрлэлтэд хүлээж авах;

Хоёр. Жолоочид тавих шаардлага:

2.1 Тээврийн хэрэгслийн жолооч нь тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, түүний нэмэгдэл төхөөрөмж, хэрэгслийн техникийн бүрэн байдал, хэвийн найдвартай ажиллагааг хангах;

2.2 Тээвэрлэлтийн ажил, үйлчилгээг эрхлэх тухайн ангиллын тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй байх;

2.3 Жилд 2 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын хувцастай байх;

2.4 Тээвэрлэлтийн болон ачих, буулгах ажиллагааны явцад ачааны физик, химийн болон хэрэглээний шинж чанарыг алдагдуулахгүй, механик гэмтэл учруулахгүй, чанарыг хадгалж хүргэх;

2.5 Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэлтийн өөр нөхцөл шаарддаг бусад ачаатай хольж ачих, тээвэрлэхгүй байх;

Гурав. Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүний тээвэрлэлтэд тавигдах шаардлага.

3.1 Хүнсний түргэн муудах эмзэг бүтээгдэхүүнийг гаднах орчны нөлөөллөөс /цас, бороо, чийг, нар, салхи, шороо, тоос гэх мэт/ хамгаалах тусгай зориулалтын битүү тэвш бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэх;

3.2 Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нь ачааг гэмтээж муутгахгүй, механик гэмтэлд оруулахгүй чанар байдлыг нь алдагдуулахгүйн тулд хана, дээвэр, суурь хэсэг нь дулаан тусгаарлагч бүхий битүү тэвш, бүхээгтэй, эсвэл эдгээр нь хөргөх юм уу хөлдөөх нэмэгдэл төхөөрөмжөөр тоноглогдсон байх;

3.3 Тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн битүү тэвш, бүхээгт хүнсний түргэн муудах, бүтээгдэхүүний шинж чанарт сөрөг нөлөө үзүүлэх ачаатай хольж тээвэрлэхгүй байх;

3.4 Түргэн муудах ачааны физик-химийн шинж чанар, хэрэглээний зориулалт, чанарыг алдагдуулахгүй тулд зориулалтын тавиур, хайрцаг, сав хэрэглэх;

3.5 Тээврийн хэрэгслийн жолооч, ачигчийг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан тусгай ажлын гутал, хувцас, бээлий зэргээр хангасан байх;

3.6 Хөлдүү болон загсаасан богын гулууз, бодын мөчилсөн махыг дулааны улиралд хөлдөөх төхөөрөмжөөр тоноглогдсон дулаан тусгаарлагч битүү тэвш, бүхээг бүхий тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр /өлгөөстэй/ тээвэрлэх;

3.7.Тусгай зориулалтын тавиурын доторх тасалгаа нь гулууз махыг өлгөөстэй байдлаар тээвэрлэхэд зориулсан, тавиурынхаа уртын дагуу гүйдэг дэгээ бүхий зэрэгцээ байршсан хөндлөвч нуруутай байх;

3.8 Хүйтний улиралд бөөнөөр нядалсан бод, бог малын их хэмжээний махыг хол зайд тээвэрлэхэд ердийн ачааны автомашины тэвшийг шороо тоос орохооргүй сайтар чигжиж, шалыг нь нимгэн мөстүүлэх, эсвэл 5,0 см-ээс багагүй зузаан цас дэвсэх, гулуузгалсан махыг босоо байдлаар ачиж брезентээр битүү хучин эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангасан тоосгүй орчин бүрдүүлж тээвэрлэх;

3.9. Мах, махан бүтээгдэхүүн, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, загас тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгслийн тэвш, бүхээгийн дотор талыг өдөр бүр зориулалтын угаалгын бодис, халуун усаар угааж цэвэрлэх;

Махыг арьс шир, нэхий болон бусад түүхий эдтэй хольж тээвэрлэхийг хориглоно.

3.10 Хагас боловсруулсан болон төрөл бүрийн амтат бүтээгдэхүүн, сүү, цагаан идээг хөргөх төхөөрөмжөөр тоногдсон зориулалтын битүү тавиур, бүхээг бүхий тээврийн хэрэгсэл /суудлын пикап, фургон, цистерн/ээр тээвэрлэх;

3.11 Төрөл бүрийн хиам хүйтэн боловсруулалтын хүнсний ногоо, жимс, загасан бүтээгдэхүүнийг стандартын хайрцаг, саванд хөргөх төхөөрөмж бүхий битүү тэвш бүхээгтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэх;

3.12 Хиам, утлагат бүтээгдэхүүнийг тусгай зориулалтын хөнгөн цагаан болон хуванцар саванд тээвэрлэх бөгөөд давхарлан өрөхөд бүтээгдэхүүн савны ёроолд хүрэхгүйгээр үелүүлэн савлагдсан байх;

3.13 Мах, махан бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтын савыг угааж, халдваргүйжүүлэх;

3.14 Гулууз мах, хиамыг зориулалтын бус саванд буюу автомашины тавиур, тавиурын хонгилд ил задгай ачиж тээвэрлэхийг хориглох;

3.15 Стандартын чингэлэг, савтай жимс, хүнсний ногоо, ургамлын тосыг гэрэл, дулаан тусгаарлагч битүү тэвш бүхий зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгслээр тээвэрлэх;

3.16 Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэх тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, түүний битүү тэвш, бүхээгт тогтмол ариутгал хийж, тээврийн хэрэгсэл бүрийг угаах, ариутгах, арчих хэрэгсэл, материалаар хангасан байх;

3.17 Тээвэрлэлт, ачиж буулгах явцад ачааны бүрэн бүтэн байдал, чанарыг алдагдуулахгүйн тулд стандартын баглаа боодол, сав хайрцаг, шошго, хаяг битүүмжлэл зэргийг урьдчилан хангуулж тээвэрлэлтэд хүлээж авах;

3.18 Түргэн муудах, эмзэг хүнсний бүтээгдэхүүнийг стандартын контейнер, хайрцаг сав, баглаа, боодолгүй, ил задгай, зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг хориглоно.

3.19 Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэж байгаа үйлдвэрлэгч, худалдаа эрхлэгч нь тээвэрлэлтийн баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн байна.

Дөрөв. Тээвэрлүүлэгчдэд тавих шаардлага:

4.1 Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэлтэд бэлтгэх, тээвэрлэлт, ачиж буулгах явцад бүрэн бүтэн байдлыг хамгаалах, чанарыг алдагдуулахгүй гадна орчны нөлөөлөл, механик гэмтэлд оруулахгүйн тулд стандартын баглаа боодол, сав хайрцагт бөөнөөр савлаж тээвэрлүүлэх;

4.2 Ачааны баглаа боодол, сав бэхэлгээ битүүмжлэл /лац ломбо/ зэргийг холбогдох стандарт, ачаа тус бүрийн тээвэрлэлтийн нөхцөлийн дагуу бүрдүүлж тээвэрлүүлэх;

4.3 Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг зөвхөн зориулалтын тээврийн хэрэгслээр, эсвэл физик, химийн шинж чанарыг нь алдагдуулахгүй, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаж тоногдсон тээврийн хэрэгслээр тээвэрлүүлэх;

4.4 Тээврийн хэрэгслийн техникийн байдал, нэмэгдэл төхөөрөмж хэрэгслийн хэвийн найдвартай ажиллагаа нь ариун цэвэр, эрүүл ахуй, экологийн шаардлагыг хангасан, жолооч эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хамрагдсан тухайн анилалын мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй эсэхийг г шалгаж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг ачуулах;

4.5 Тусгай зориулалтын битүү бүхээг, тэвшинд хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүний ачааг бөөний хайрцаг, сав, баглаа, боодолтой тээвэрлүүлэх бөгөөд тээвэрлэлт, ачиж буулгах ажиллагааны технологийн болон стандартын шаардлагыг хатуу баримтлах;

4.6 Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэгч, зуучлагч, тээвэрлүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээнүүдэд хадгалалтын онцгой горим, нөхцөл шаардагддаг хүнсийг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх, талаар тодорхой заалт тусгах, хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлтэнд тавих шаардлагын талаар дотооддоо сургалт зохион байгуулж байхын зэрэгцээ холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмыг сайтар сурталчилан таниулах шаардлагатай байна.

Зам, тээврийн осол гарах, давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан автозамын тээвэрлэлт зогсох, саатах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд яаралтай мэдэгдэж хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлж байхыг зөвлөө.

ХҮНСНИЙ ЧАНАР, СТАНДАРТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Я.БАТЦАГААН

АВТОТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

П.ТАМИР